

**ОРХОН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
Стратеги төлөвлөгөөний зорилго-1: Орон нутгийн өмчийг үр ашигтай, үр дүнтэй, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах							
1.1	Зорилт-1: Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэх / ЗГҮАХ-4.1.4.2, ЗГХЭГ-ын сайд-2.3.7/						
1.1.1	Арга хэмжээ-1: Төрийн өмчөөс орон нутгийн өмчид, орон нутгийн өмчөөс эд хөрөнгийг төрийн өмчид, орон нутгийн өмчит байгууллагын эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн шийдвэрлэлтийн хувь	Орон нутгийн өмчийн байгууллага хооронд балансаас баланст хөрөнгө шилжүүлэх 19 байгууллагын хүсэлтийг хүлээн авч тухай бүр захирамж шийдвэрүүдийн дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулан хөрөнгийн хөдлөлийг хууль тогтоомж, журмын дагуу хийж гүйцэтгэсэн.	100 хувь	/I-IV улирал/	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
1.1.2	Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дахин үнэлэх, үнэлгээг шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах, өөрчлөх асуудлаар ирүүлсэн санал, захиалгыг хянах, шийдвэрлүүлэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Шийдвэрлэлтийн хувь	АЗД-ын 2025.04.09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/278 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс ашиглалтын гэрээгээр эзэмшиж буй байр, талбай, барилга байгууламжийн ашиглалтын байдалд судалгаа, хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч, ажлын хэсгийг шийдвэрийг 2025.06.24-ний өдрийн АЗД-ын хуралдаанд танилцуулж 5 байрыг дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлүүлэн дахин үнэлгээг “Арвижих-эстимейт үнэлгээ” ХХК-иар хийлгэж 2025.06.11-ний 25/610 тоот дүгнэлтийг гаргуулсан	100 хувь	/I-IV улирал/	Хариуцсан мэргэжилтэн
1.1.3	Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, актлах санал, захиалгыг судлах, хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэх, орон нутгийн өмчөөс худалдах эд хөрөнгийн жагсаалт гаргах, зохион байгуулах, мэргэжил, арга зүйн	Байгууллагын батлагдсан төсвөөр	Шийдвэрлэлтийн хувь	2025.04.09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах ”А/278-р захирамж, АЗД-ын 2025.08.27-ны өдрийн А/709-р захирамж, АЗД-ын 2025.11.25-ны өдрийн А/1003-р захирамжуудын хүрээнд хөрөнгийг худалдах, актлах санал захиалгын дагуу хянаж судлан шийдвэрлэж ажилласан.	100 хувь	/I-IV улирал/	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн

	зөвлөгөө өгч ажиллах, орон сууц хувьчлах товчооны үйл ажиллагаанд оролцох						
1.1.4	Арга хэмжээ-4: Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах зорилгоор холбогдох журам, зааврыг боловсруулах, танилцуулах, түрээсийн төлбөрийн хэмжээг зах зээлийн үнэд нийцүүлэн тогтоох тогтоолын төслийг бэлтгэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх, түрээсийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Түрээсийн орлогын төлөвлөгөөний хувь	АИТХ-ын 2025.03.24-ний өдрийн 02/18-р тогтоолоор өмчтэй холбоотой 4 журам, мөн өдрийн 02/20-р тогтоолоор өмчтэй холбоотой гэрээний загвар түүнийг дүгнэх аргачлалыг тус тус батлуулсан. Орон нутгийн өмчийн байр талбайн түрээсийн гэрээг 31 байгууллага, 54 иргэнтэй байгуулж, Шууд түрээсийн орлого 90,3%, дам түрээсийн орлого 90.1 % буюу ТОСХ-р хэрэгжсэн 315 айлын орон сууцны эргэн төлөлтөд 2.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.	100 хувь	/I-IV улирал/	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
1.1.5	Арга хэмжээ-5: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар болон цаасаар хүлээн авч нэгтгэх, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймгийн Засаг даргын нэгдсэн санхүүгийн тайлантай тулган, хяналт тавих, орон нутгийн өмчийн нэгдсэн дүн мэдээг улсын хэмжээнд нэгтгүүлэх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Тайлан нэгтгүүлэх байгууллагын тоо	Орон нутгийн өмчит 100 байгууллагын 786,606,294,424.26 төгрөгийн үндсэн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, Сангийн яамны и-баланстай нэгтгэн тулган баталгаажуулж 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлсэн.	100	/I-IV улирал/	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
1.1.6	Арга хэмжээ-6: Орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгох, удирдлага, зохицуулалтаар хангах, мэдээллийн санг баяжуулах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд бүртгэлээр системийн хяналт хийх, дүгнэлт гаргах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Гүйцэтгэлийн хувь	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 121 ажил, бараа худалдан авах 44, БӨ сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54 ажил, бараа худалдан авах 51, Жаргалант сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 23 ажил, бараа худалдан авах 48, Болзошгүй аваарын зардлаар хийгдсэн 204 ажлыг хүлээн авах комисст холбогдох мэргэжилтнүүд ажиллаж, хөрөнгийг санхүүгийн программд бүртгэснийг шалган бүртгэлээр системийн хяналт тавьж ажилласан.	100 хувь	/I-IV улирал/	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн

1.1.7	Арга хэмжээ-7: Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн өмчийн хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт хийх, дүнг нэгтгэн тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Гэрээ байгуулсан байгууллагын тоо	АИТХ-ын 2025.03.24-ний өдрийн 02/20-р тогтоолоор өмч эзэмшлийн гэрээний загвар, дүгнэх аргачлалыг батлуулсан. Үүний дагуу 2025.05.30-ны өдөр орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч нартай өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин гэрээг дүгнэж ажиллаж байна..	100	/I-IV улирал/	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн
Стратеги төлөвлөгөөний зорилго-2: Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагад хяналт тавьж, бүрэн бүтэн байдлыг хангуулах зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах							
2.1	Зорилт-1: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад баримтын иж бүрэн болон системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх /ЗГХЭГ-ын сайд-2.3.6/						
2.1.1	Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Баримтын шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо	Аймгийн Засаг Даргаар баталгаажсан 3 бүлэг, 38 заалт бүхий шалгалтын удирдамж, төлөвлөгөөний дагуу - “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ, - “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, - “Хот тохижуулах газар” УТҮГ-д хяналт, шалгалт, мөн АЗДТГ-ын СТСХ-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 08/2480 дугаар албан бичгийн дагуу “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-т төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийж үр дүнг (хаана) танилцуулж ажилласан.	6	/I-IV улирал/	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн
2.1.2	Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад системийн хяналт шалгалт хийх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын системийн шинэчлэлттэй холбоотойгоор орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн үнэн зөв байдалд системийн хяналт тавьж хөрөнгийн ангилал буруу бүртгэлтэй холбоотой 63 байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөвлөмж хүргүүлж ажилласан. Аймгийн ЗД-ын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/260 дугаар захирамжийн дагуу 59 байгууллагын 8,029,246,199.00 төгрөгийн 615 нэгж хөрөнгийн ангилал залруулах, 11,984,078,186.00 төгрөгийн 204 нэгж	2	/I-IV улирал/	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн

				хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг системд хийсэн. 63 хуулийн этгээдийн нэрийг УБГ-тэй тулган системд засварласан, газар эзэмшилт, ашиглалттай холбоотой 78 байгууллагын 391 газрыг www.egazar.gov.mn, 40 байгууллагын 401 тээврийн хэрэгслийн бүртгэлийг www.transdep.mn цахим бүртгэлтэй тулган баталгаажуулсан. Мөн хөрөнгө актлах хүсэлт гаргасан 16 байгууллагын хөрөнгөд хяналт тавьж, 56,225,137.81 төгрөгийн балансын үнэ бүхий 33,492,142.20 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 22,732,995.61 төгрөгийн үлдэх өртөгтэй 160 нэгж хөрөнгийг актлахаар АЗД-ын 2025 оны А/1003 тоот захирамж гаргуулсан.			
2.1.3	Арга хэмжээ-3: Хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн сан бий болгох, бүртгэл мэдээллийн баяжилт хийх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хэрэгжилтийн хувь	ТБОНӨ-ийн удирдлага, бүртгэл, зохицуулалтын шинэ системд “хяналт шалгалтын модуль” шинээр нэмэгдэж байгаатай холбогдуулан ТӨБЗГ-ын даргын 2025. 01. 22-ны А/07 тушаалаар “Цахим систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний тухай”, АЗД-ын 2025.02.05-ны өдрийн А/94 -р захирамжийн дагуу орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг хүлээн авч нэгтгэн ТӨБЗГ-аар 2025.05.05-ны өдөр хүргүүлсэн. ТБОНӨ-ийн мэдээллийн шинэ системийн туршилтыг ТӨ-т 8 байгууллага, ОНӨ-т 10 байгууллагад хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан. ТӨБЗГ-ын 2025.08.06-ны өдрийн А-1/1538 тоот албан бичгийн дагуу "ТБОНӨ-ийн цахим систем"-ийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн цахим системтэй холбох ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 4 албан хаагч 2025.08.25-28-ны өдрүүдэд хамрагдсан. 2025.10.06 - 07-ны өдрүүдэд	100 хувь	/I-IV улирал/	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан

				ТӨБЗГ, “Аствишн” ХХК-ийн систем шинжилгээ, загварчлалын хэлтэс болон байгууллагын сургагч багш нар хамтран шинэ цахим системийн талаарх сургалтыг Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ТБОНӨ-т 126 байгууллагын 135 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.			
Стратеги төлөвлөгөөний зорилго-3: Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагыг оновчтой, үр ашигтай, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах							
3.1	Зорилт-1: Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх /ЗГҮАХ-3.1.2.4, ЗГХЭГ-ын сайд-2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.4, 2.3.5/						
3.1.1	Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг албан ёсны цахим хуудсанд тогтмол байршуулах /ЗГХЭГ-ын сайд-2.3.3/	Байгууллагын батлагдсан төсвөөр	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо	Аймгийн ЗД-ын 2025.01.17-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/25-р захирамжаар Орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүнийг сонгох ажлын хэсэг байгуулагдсан. Мөн АИТХ-ын 2025.03.24-ний өдрийн 02/17-р тогтоолоор “Орон нутгийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл”-ийг томилсон. Ажлын хэсгээс сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн материалыг 2025.04.30-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан. “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК болон, “Жаргалант ус ДТС” ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025.07.09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, “Жаргалант ус ДТС” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг тус бүр 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.	2	/I-IV улирал/	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн
3.1.2	Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Арга хэмжээний тоо	Аймгийн ЗД-ын 2025.02.18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/144 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг АЗД-тай “Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий гэрээ” - тэй 4 ОНӨААТҮГ, 2 ОНӨХК, 4 УТУГ-ын 2024 оны ажлын тайлан, 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөг нь хянаж, үнэлэлт дүгнэлт зөвлөмж өгч ажилласан.	1	/I-IV улирал/	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн, Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах

				Компанийн засаглалын сургалтыг АИТХ-ын ажлын алба, “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, “Жаргалт хаан хайрхан консалтинг” ХХК-тай хамтран 2025 он 12 дугаар сард зохион байгуулсан.			мэргэжилтэн
3.1.3	Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, үйлдвэрлэл, техник технологи, санхүү эдийн засаг, хүний нөөцийн төлөв байдалд судалгаа, шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах, алдагдалыг бууруулах ажлыг зохион байгуулах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Арга хэмжээний тоо	АЗД-тай “Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий гэрээ” - тэй 4 ОНӨААТҮГ, 2 ОНӨХК, 4 УТҮГ-ын бүхий хөдөлмөрийн гэрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийн “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ - 64.44 хувь , “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” АӨЗ - 83.75 хувь , “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ - 52.05 хувь , “Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар” УТҮГ - 53.04 хувь , “Хот тохижуулах газар” УТҮГ - 71.93 хувь , “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” УТҮГ - 64.03 хувь тай тус тус үнэлэгдсэн ба цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажилласан. Эрдэнэ шинжлэх ухаан, технологийн парк нь ажлын тайлан ирүүлсэн боловч 2025 оны төлөвлөгөөг батлуулаагүй тул үнэлэх боломжгүй байна.	4	/I-IV улирал/	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн, Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
Стратеги төлөвлөгөөний зорилго-4: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх мэргэшсэн чадварлаг баг бүрдүүлэх, хүний нөөцийн болон санхүү, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.							
4.1	Зорилт-1: Байгууллагын чадавхыг сайжруулж, бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор зөвшөөрөл олгож, баталсан албан тушаалын тодорхойлолтын чиг үүргүүдийг хангахуйцаар зохион байгуулж, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хийдэл, давхардал гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах /ЗГХЭГ-ын сайд-2.3.8/						
4.1.1	Арга хэмжээ-1: Хүний нөөцийн асуудлаар холбогдох судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, авах арга хэмжээ, шийдвэрийн санал, төсөл боловсруулах, танилцуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Боловсруулсан төсөл арга хэмжээний тоо	“Сургалтын төлөвлөгөө”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө” гарган ажилласан. Байгууллага маань өөрийн гэсэн байртай болж иж бүрэн засвар үйлчилгээг хийлгүүлж албан хаагчдын	2	I-IV	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

				ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.”			
4.1.2	Арга хэмжээ-2: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	“Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө”-г 5 бүлэг 18 заалттайгаар баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ нялх хүүхэдтэй 1 албан хаагч болон суралцан мэдлэг чадвараа дээшлүүлж байгаа 1 албан хаагчийн ажиллах цагийг богиносгож, дотоод журамд заасны дагуу 2 албан хаагчдад тус бүр 500.0 төгрөгийн дэмжлэг үзүүлж, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд 1,760,000 төгрөгийн гарын бэлэг тус тус олгосон.	100 хувь	I-IV	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
4.1.3	Арга хэмжээ-3: Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	2025 оны “Сургалтын төлөвлөгөө”-г 10 төрлийн агуулга сэдвийн хүрээнд төлөвлөж ТА3-ийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан. “ТЖАХ-г мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт”-д 1, “Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт”-д 4 албан хаагч хамрагдснаас гадна http://surgalt.gov.mn -ий 15 цахим сургалтад албан хаагчид хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. ТА3-ийн 7:4:10 вебинар, болон цаг үеийн шинжтэй зохион байгуулагддаг бусад сургалтуудад нийт албан хаагчдаа бүрэн хамруулж мэдлэг мэдээллийг нь сайжруулан ажилласан.	100 хувь	I-IV	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
4.1.4	Арга хэмжээ-4: Хүний нөөцийн цахим систем, төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлт, хүний нөөцийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Системд шинэчлэл хийсэн тоо	ХНУМТ цахим системд 8 удаагийн өөрчлөлт, хөдөлгөөнийг хийсэн. Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг Төрийн албаны зөвлөлийн 2022.11.14-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу бүрдүүлэлтийг тухай бүр хийж хэвшсэн. Тайланг ТА3-ийн Орхон аймаг дахь салбар зөвлөл рүү хүргүүлэн ажиллаж байна.	14	I-IV	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

4.1.5	Арга хэмжээ-5: Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийг байгууллагынхаа хэмжээнд мөрдөн ажиллах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Харьцааны хувь	АЗД-ын 2025.04.16-ны өдрийн А/308 дугаар захирамжийн дагуу 14 албан хаагчтай. Үүнээс 11 эмэгтэй, 3 эрэгтэй буюу 79:21 харьцаатай. Хууль тогтоомжийн хүрээнд 40:60 харьцааг хангахыг зорьж байгаа ч тусгай шалгалтын шаардлагад хүйс заах боломжгүй тул шалгалтад тэнцэн орж ирж буй албан хаагчдаар хүйсийн харьцаа тодорхойлогдож байна.	100 хувь	I-IV	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
4.2	Зорилт-2: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандарт, зааврын дагуу хөтлөх, ил тод нээлттэй мэдээллэх”						
4.2.1	Арга хэмжээ-1: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, бусад холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, тайлант жилийн үйл ажиллагааны зардлын төсвийг бодитой төлөвлөн хянуулж батлуулах, төсвийг үр дүнтэй бодитой зарцуулах, тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Тайлант жилийн төсвийн төслийг үндэслэл тооцоотой боловсруулан, Санхүү төрийн сангийн хэлтэст хянуулан, fiscal 5.5 системд шивж баталгаажуулан, ИТХ-ын 2024 оны 03/13 дугаар тогтоолын дагуу 734.2 сая төгрөгийн төсвийг батлуулан, санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу авч зардлын зүйл, хөтөлбөр, зориулалтын дагуу зарцуулан ажилласан байна. Нийт 711.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 671.6 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 99.4 хувьтай байна. 40.2 сая төгрөгийг буцаан татан төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд үүссэн болон он дамжсан өр, авлага байхгүй болно.	100 хувь	I-IV	Нягтлан бодогч
4.2.2	Арга хэмжээ-2: Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, данс бүртгэлээр хяналт тавих	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хяналтын хувь	Тайлант хугацаанд холбогдох шийдвэрүүдийг үндэслэн 4,465.0 сая төгрөгийн барилга байгууламж, 248.8 сая төгрөгийн нийтийн эзэмшил, 33,2 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 45,0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 911.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 250.8 сая төгрөгийн тавилгыг үнэ төлбөргүй, 15.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 11.9 сая төгрөгийн тавилгыг худалдан авч орлогод бүртгэн, 3,806.5 сая төгрөгийн барилга байгууламж, 1,272.4 сая төгрөгийн нийтийн эзэмшил, 424,0 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 5,8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 163,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 192.7 сая	100 хувь	I-IV	Нягтлан бодогч Нярав

				төгрөгийн тавилгыг бусад байгууллагад шилжүүлж, 14.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.4 сая төгрөгийн тавилгыг акталж данс бүртгэлээс хассан байна. Тайлант жилийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээллийг 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн болон төрийн өмчийн бүртгэлийн системд бүрэн оруулж, хариуцсан мэргэжилтэнд хянуулж баталгаажуулсан. Хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулан явуулж хэвшсэн			
4.2.3	Арга хэмжээ-3: Байгууллагын балансад бүртгэлтэй хөрөнгийг “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-гээр ашиглаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Байгууллагын батлагдсан төсвөөр	Тооллого хийсэн тоо	Орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулан, хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогод хамруулж, ашиглалтын байдалд хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд 12 төрийн байгууллагатай 869.7 сая төгрөг, 4 төрийн бус байгууллагатай 929.1 сая төгрөг, 3 аж ахуйн нэгж байгууллагатай 1,889.5 сая төгрөгийн хөрөнгийг эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээгээр ашиглуулж байна. Хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогод хамуулан, жилийн эцсийн тооллогоор хөрөнгийг газар дээр нь үзэж тоолон, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилласан.	2	I-IV	Нягтлан бодогч Нярав
4.2.4	Арга хэмжээ-4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хариуцан гүйцэтгэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хэрэгжилтийн хувь	Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр мэдээллэх 9, сар бүр мэдээллэх 4, жил бүр мэдээллэх 3 талбарт санхүүгийн мэдээллийг хугацаанд нь байршуулж, ил тод болгож хэвшсэн. Тайлант хугацаанд мэдээллэх ёстой 136 талбарт санхүүгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан ба эхний 3 улирлын үнэлгээгээр 98,6 хувьтай үнэлэгдсэн байна.	100 хувь	I-IV	Нягтлан бодогч
4.3	Зорилт-3: Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалт, орон нутгийн өмчит компанийн засаглал, дотоод, гадаад хяналт шалгалт, хууль эрх зүйн, өмчийн хөдөлгөөн, зохицуулалтын чиглэлээр мөрдөж буй журам, аргачлал, зааврын хуулийн нийцлийг хангуулах арга хэмжээ авах /ЗГХЭГ-ын сайд-2.3.9/						
4.3.1	Арга хэмжээ-1: Хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг,	Байгууллагын батлагдсан	Боловсруулсан баримт бичгийн	Газрын даргын А тушаал 55, Б тушаал 12 нийт 67 тушаал, 1505 албан бичиг,	1000	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ,

	тогтоол, шийдвэр, журам, дүрэм, аргачлал, заавар зэрэг баримт бичгийн санал, төсөл боловсруулах, батлуулах	төсвөөр	тоо	аймгийн Засаг даргаас “Гэрээ байгуулж, хяналт тавих тухай” ирүүлсэн 45 мэдэгдлийг хүлээн авч гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан. АЗД-ын захирамжийн 12 төсөл, АИТХ-ын тогтоолын 5 төслийг тус тус хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, боловсруулж батлуулсан. Мөн байгууллагын дүрмийн төслийг боловсруулж АЗД-ын 2025.04.16-ны өдрийн “Орон нутгийн өмчийн газрын дүрэм, орон тоог өөрчлөн батлах тухай” А/308 дугаар захирамжаар албажуулж Улсын бүртгэлд бүртгүүлсэн.			үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.3.2	Арга хэмжээ-2: Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэр, журам, дүрэм, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр, аймгийн хөгжлийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Хэрэгжилтийн хувь	Монгол Улсын хууль 4, Улсын Их Хурлын тогтоол 1, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол 5, Засгийн газрын тогтоол 16, хуралдааны тэмдэглэл 13, албан даалгавар 15, АИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 1, АИТХ-ын тогтоол 6-г хяналтад авч хэрэгжилтийг ханган биелэлтийг тайлагнахаас гадна Орхон аймгийн ЗД-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.1.3.1, 4.2.1.3.2-д тусгагдсан 2 арга хэмжээ, Орхон аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2 арга хэмжээ, Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн гүйцэтгүүлэх 2025 оны гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 9 арга хэмжээ, аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын шуурхай хуралдаан болон АЗД-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, ИТХ-ын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, ЗД-ын захирамж зэргийн хэрэгжилтийг тус тус хангаж, биелэлтийг тухай бүр аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-рүү хүргүүлэн ажилласан.	100 хувь	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.3.3	Арга хэмжээ-3: Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг	Байгууллагын батлагдсан	Төлөвлөгөөний биелэлтийн	Авлигын эсрэг 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд нийцүүлж	100 хувь	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ,

	төлөвлөх, зохион байгуулах, харьяа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдүүлэг бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах	төсвөөр	хувь	байгууллагын авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 9 заалттайгаар төлөвлөж биелэлтийг ЗДТГ-ын ХЭЗХ-т цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Шинээр томилогдсон албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар сургалт мэдээлэл өгч ажилласан. ХАСХОМ гаргадаг албан хаагчид хуулийн хугацаандаа мэдүүлгээ хүргүүлж ажилласан.			үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.3.4	Арга хэмжээ-4: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэхэд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг албан хаагчдад сурталчлан таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах.	Байгууллагын батлагдсан төсвөөр	Сургалтын тоо	ЗГ-ын 2025.01.29-ний өдрийн “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” зэрэг журмуудыг байгууллагын албан хаагчдад танилцуулсан. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ анхаарах асуудлын талаар албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. АЗДТГ-ын ХШҮХ-с 2025.06.10-нд зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан шинэ журмуудыг хэрэгжүүлэх талаарх сургалт”-д байгууллагын төрийн захиргааны 9 албан хаагчийг хамруулсан.	4	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.3.5	Арга хэмжээ-5: Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах, мэдээлэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Хяналтад авсан “Бодлогын баримт бичиг”-т хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын дотоод үйл ажиллагаанд дотоод аудит хийх төлөвлөгөөг 2025.02.14-ний өдөр 2 бүлэг 10 заалттайгаар батласан. Төлөвлөгөөний дагуу холбогдох мэргэжилтэн байгууллагын санхүү, архив, албан хэрэг хөтлөлтийн байдал, хүний нөөцийн системийн ашиглалт, хувийн хэргийн бүрдэл зэрэгт дотоод аудит хийсэн. 2025.05.13-16-ны хооронд орон нутгийн өмчит 11 хуулийн этгээдийн санхүү, хүний нөөц, архив, албан хэргийн	90 хувь	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн

				хөтлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөгөө, мэдээллээр хангасан. Мөн төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болох гэж байгаагаар холбогдуулан 2025.09.12-16-ны өдрийн хооронд байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн.			
4.3.6	Арга хэмжээ-6: Тухайн жилд дотоод аудит, дотоод хяналт хийх чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг тайлагнах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100 хувь	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.3.7	Арга хэмжээ-7: Дотоод хяналтын үр дүнгээр гарсан зөрчил, дутагдлын талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих	Байгууллагын батлагдсан төсвөөр	Зөвлөмжийн тоо	Байгууллагын дотоод хяналт, шалгалтаар ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй. Орон нутгийн өмчит 10 байгууллагын хүний нөөцийн цахим системийн мэдээлэл дутуу, албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, тушаал, албан бичгийн бүрдэл дутуу зэрэг нийтлэг зөрчил илэрсэн ба байгууллага тус бүр зөвлөмж хүргүүлсэн.	2	I-IV	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.4	Зорилт-4: Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал /ЗДҮАХ-4.2/						
4.4.1	Арга хэмжээ-1: Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо сайжирч, орон нутгийн өмчит байгууллагуудын оновчтой бүтэц бий болж, зохион байгуулалтыг сайжруулах /ЗДҮАХ-4.2/	Байгууллагын батлагдсан төсвөөр	ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	АИТХ-ын 2025.03.24-ний өдрийн 02/21-р тогтоолоор Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ, Хотын захирагчийн албаны чиг үүргийн давхардлыг арилгаж ангилал өөрчилсөн, 2025.06.26-ны 03/29-р тогтоолоор "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" УТҮГ-ыг татан буулгаж нэршил өөрчилсөн, АЗД-ын 2025.08.27-ны өдрийн А/710 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн хурлаас "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж" УТҮГ-г Хот тохижуулах газартай 2027.01.01-ний өдрөөс нэгтгэх, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ-г тохижилтын ажил хийж дууссаны дараа татан буулгаж ОНӨ-ийн ХХК болгохоор шийдвэрлэсэн.	100 хувь	I-IV улиралд	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.4.2	Арга хэмжээ-2: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, орон нутгийн	Байгууллагын батлагдсан төсвөөр	Мэдээлэл байршуулсан байгууллагын	Орон нутгийн өмчит 10 байгууллага нь "И-Монгол академи" УТҮГ-с хөгжүүлж буй e-mongolia.mn төрийн байгууллагын	10	I-IV улиралд	Өмчийн удирдлага, төлөөлөл

	өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг холбогдох бусад мэдээлийг албан ёсны цахим хуудсанд тогтмол байршуулах /ЗГХЭГ-ын сайд-2.3.1/		тоо	нэгдсэн удирдлагын системд мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. “Эрдэнэт ус, ДТС” ОНӨХК нь http://www.erdenet-us.gov.mn, “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ нь http://www.erdenetpark.mn, “Хот байгуулалт, барилга захиалагчийн газар” УТҮГ нь http://www.erdenetbarilga.mn зэрэг 3 байгууллага нь сошиал хаягаараа мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.			хариуцсан мэргэжилтэн
4.4.3	Арга хэмжээ-4: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд тусгах /ЗГХЭГ-ын сайд-2.3.5/	Байгууллагын батлагдсан төсвөөр	Гэрээнд тусгасан заалтын тоо	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захиралтай байгуулсан 2025 оны Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд Үйл ажиллагаандаа ТБОНӨТ хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллах” гэсэн тусгайлсан 5 заалт 7 арга хэмжээг оруулсан.	5	I-IV улиралд	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн
4.4.4	Арга хэмжээ-5: Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Байгууллагын батлагдсан төсвөөр	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 3 зорилт, 9 заалттай, “Байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-г 1 бүлэг 9 заалттайгаар 2025.02.03-ны өдөр батлан АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст мөн өдрийн 40 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахын зэрэгцээ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллагын албан хаагчдад сургалт, зөвлөгөөг 4 удаа зохион байгуулан ажилласан.	100 хувь	I-IV улиралд	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн

4.4.5	Арга хэмжээ-6: И-оффис системийг байгууллагынхаа хэмжээнд бүрэн ашиглаж цаг хугацаа, цаас хэмнэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах	Байгууллагын батлагдсан төсвөөр	И-оффис системийн ашиглалтын хувь	Байгууллагад ирсэн 588 албан бичгийг цаасаар болон цахимаар хүлээн авч, и-оффис системд бүртгэж холбогдох албан хаагчдад шилжүүлж, байгууллагаас явуулсан 1505 албан бичгийн төслийг “албан бичиг төлөвлөлтийн модуль”-ийг ашиглан боловсруулж батлуулан и-оффис систем, и-мэйл хаяг болон цаасан хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. И-Оффис системд албан хаагч бүр 7 хоног бүрийн ажлын төлөвлөгөө, тайлангаа оруулж, дотоод имэйл ашиглаж цаг хугацаа болон цаас хэмнэж төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100 хувь	I-IV улиралд	Хариуцсан албан хаагч
4.4.6	Арга хэмжээ-7: Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэх	Байгууллагын батлагдсан төсвөөр	Шийдвэрлэлтийн хувь	2025 онд нийт 1183 өргөдөл, хүсэлт ирсэн ба иргэн өөрийн биеэр 57, АЗДТГ-с шилжүүлсэн 42 байна. Үүнээс 109-д нь утсаар, 49-д нь биечлэн хариу өгч шийдвэрлэсэн. Өргөдөл хүсэлтийг ангилбал: ТОС хүссэн, 113 ТОС-ны гэрээ сунгуулах-22, түрээсийн ажлын байр хүссэн 20, ажлаас чөлөөлөгдөх 1, шугам сүлжээ хүлээлгэн өгөх 1, цахилгааны ажил хүлээлгэн өгөх 1 хүсэлт, ОНОС хөтөлбөрийн хүрээнд цахимаар 1025 иргэн хүсэлт ирүүлснээс шаардлага хангасан эхний 63 иргэнд биечлэн, бусад 962 иргэнд цахимаар хариу өгч ажиллалаа.	80 хувь	I-IV улиралд	Хууль, хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.4.7	Арга хэмжээ-8: Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, албан хаагчдад ёс зүйн хэмжээ, холбогдох хууль тогтоомжийг сахих	Байгууллагын төсвөөр	Арга хэмжээний тоо	Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025.02.17-ны өдөр 8 заалттайгаар боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган, биелэлтийг тайлагнан ажилласан. Газрын даргын 2025.10.03-ны “Байгууллагын ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай” А/42 тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн.	4	I-IV улиралд	Хууль, хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн

4.4.8	Арга хэмжээ-9: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэн, нийтэд мэдээллэх мэдээллийг тухай бүр байршуулах	Байгууллагын төсвөөр	Хэрэгжилтийн хувь	Хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудас, "И-Монгол-Академи" УТҮГ-с хөгжүүлж буй e-mongolia.mn төрийн байгууллагын нэгдсэн удирдлагын системд 5 бүлгийн 87 талбарт байршуулж, 95 хувийн биелэлттэй үнэлэгдсэн.	90 хувь	I-IV улиралд	Нягтлан бодогч
4.4.9	Арга хэмжээ-10: Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллах	Байгууллагын төсвөөр	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	2025 оны байдлаар АЗД-ын болон АЗДТГ-ын шуурхай зөвлөгөөнөөс нийт 62 үүрэг даалгавар өгснийг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан.	100 хувь	I-IV улиралд	Хууль, хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
4.4.10	Арга хэмжээ-11: Байгууллагын ойр орчмын 50 м газрынхаа цас мөс, хог цэвэрлэгээг тогтмол хийж байх	Байгууллагын төсвөөр	Үйл ажиллагааны тоо	Орчны цэвэрлэгээний ажлыг 3 , цас, мөс цэвэрлэх ажлыг 4 удаа зохион байгуулж бусдад зөв дадал уриалга түгээх зорилгоор байгууллагын сошиал хаягт мэдээлэл оруулж ажилласан. Цаашид нөхцөл шаардлагын хүрээнд тогтмол хийж ажиллана.	7	I-IV улиралд	Хариуцсан албан хаагч
4.4.11	Арга хэмжээ-12: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого, чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, эрх бүхий албан тушаалтныг мэргэжлийн зөвлөгөө, цаг үеийн мэдээллээр хангах, гаргах шийдвэр, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, өмчийн харилцааны асуудлаар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчид болон санхүү, бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангах	Байгууллагын төсвөөр	Сургалтын тоо	Орон нутгийн өмчит байгууллага хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнуудад чиглэсэн зөвлөгөө мэдээллийг байнга өгч ажилладаг. "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын шилжилтийн суурь систем"-д хөдлөл өөрчлөлтийг хэрхэн оруулах тухай сургалт , "Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэх талаар арга зүйн зөвлөгөөг өгч, туслалцаа үзүүлэх сургалт", "Шинэ цахим системийн талаарх сургалт" зэрэг 3 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 126 байгууллагын 405 албан хаагчийг хамруулан сургалт мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.	3	I-IV улиралд	Хариуцсан албан хаагч

ХАВСРАЛТ №1. БАЙГУУЛЛАГЫН 2026 ОНЫ ТӨСӨВ

№	Зардлын зүйл анги	Төлөвлөгөө /мян.төг/
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	542,137.4
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,767.2
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,888.7
4	Хангамж, бараа материалын зардал	16,992.0
5	Нормативт зардал	-
6	Эд хогшил, урсгал засварын зардал	6,540.0
7	Томилолт, зочны зардал	18,320.0
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	80,366.0
9	Бараа, үйлчилгээний бусад зардал	1,000.0
10	Хүүхэд хамгааллын зардал	5,400.0
11	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	6,200.0
Төсвийн нийт дүн		773,611.3